

ШУТИС-ИЙН 2024-2025 ОНЫ ХАМТЫН ГЭРЭЭ

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Хамтын гэрээний зорилго нь ШУТИС-ийн Үйлдвэрчний эвлэлийн гишүүн профессор багш, ажилтны хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбогдсон хууль ёсны ашиг сонирхлыг хуулиар тогтоосон баталгаанаас илүү нөхцөлөөр хангах, Хөдөлмөрийн тухай хуулиар шууд зохицуулаагүй асуудлыг шийдвэрлэхэд оршино.

1.2 Монгол улсын Хөдөлмөрийн тухай хууль, Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, бусад холбогдох хууль, хуульчилсан актуудыг үндэслэн ажил олгогчийг төлөөлж, ШУТИС-ийн Захиргаа, хамт олныг төлөөлж, Үйлдвэрчний эвлэлийн хороо (ҮЭХ) /цаашид талууд гэх/ харилцан тохиролцож, энэхүү хамтын гэрээг байгуулав.

1.3 Хамтын гэрээ нь ШУТИС-ийн профессор багш, ажилтны цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал олгох, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааг хангах, талуудын хамтын үйл ажиллагааг идэвхжүүлэх харилцааг зохицуулна.

1.4 Хамтын гэрээ байгуулагч талуудын харьяалал, удирдлагын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдөх нь хамтын гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

1.5 Энэхүү гэрээ нь 2024 оны 09-р сарын 15-аас 2026 оны 01-р сарын 05-ны өдөр хүртэл хугацаанд хүчин төгөлдөр байна.

1.6 Хамтын гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд талууд бие биедээ бичгээр хүсэлт гаргаснаас хойш ажлын 3 өдрийн дотор асуудлыг авч хэлэлцэнэ.

1.7 Хамтын гэрээний хэрэгжилтийг хангах ажлын төлөвлөгөөг Талууд хамтран боловсруулж хэрэгжүүлнэ. Ажлын төлөвлөгөөг гэрээний хавсралтаар батлах бөгөөд гэрээний салшгүй хэсэг байна.

1.8 ШУТИС-д дагаж мөрдөх дүрэм журмын хэрэгжилтэд гэрээнд оролцогч талууд хяналт тавьж ажиллана.

Хоёр. Хөдөлмөрийн харилцаа, цалин хөлс, нэмэгдлийн талаар

2.1 ШУТИС-ийн Дүрэм, Хүний нөөцийн бүрдүүлэлт, сонгон шалгаруулалтын журамд заасан хугацаатай томилогдож буй албан тушаалтнаас бусад профессор багш, ажилтантай сургуулийн захиргаа, бүрэлдэхүүн сургуулийн захирал нь Монгол улсын Хөдөлмөрийн тухай хуулийн холбогдох заалтын дагуу хөдөлмөрийн гэрээг хугацаагүй байгуулах бөгөөд жил бүр дүгнэж, шаардлагатай тохиолдолд нэмэлт өөрчлөлт оруулна.

2.2 МУ-ын Үндсэн хуулийн дагуу профессор багш нарын цагийн сургалтын хичээллэх цаг, цагийн тооцоог ШУТИС-д мөрдөж буй цаг тооцох журмаар бүрэн тооцож, хөлсийг нь олгоно.

2.3 ШУТИС-ийн профессор багш, ажилтны үндсэн цалинг 2024 оны 09-р сарын 15-ны өдрөөс 30 хувиар, 2025 оны 4 дүгээр сарын 1-нээс 8 хувиар, мөн оны 9 дүгээр сарын 1-нээс 12 хувиар тус тус нэмэгдүүлнэ.

2.4 Профессор багш нарын заавал биелүүлэх ноогдлоос давсан илүү кредит цагийн нэг кредитийн үнэлгээг ШУТИС-ийн профессор, багшийн ажлын гүйцэтгэлийг кредитээр тооцох журмын дагуу тооцож олгоно.

2.5 Профессор багш нар хүрэлцээгүй, зайлшгүй тохиолдолд илүүгийн илүү цагийн хөлсийг цаг тооцох журамд зааснаар тухайн хичээлийн жилд бодож олгоно.

2.6 ШУТИС-ийн профессор багш, ажилтны цалин хөлсийг сард 2 удаа олгоно. Хэрэв энэ өдөр нь нийтээр амрах баярын өдөртэй давхцавал урьд өдөр нь олгоно.


2.7 Нийтээр амрах баярын өдөр тасарсан хичээлийг профессор, багш нар агуулгаар нь нөхөх үүрэгтэй бөгөөд ийнхүү тасарсан хичээлийг багшийн гүйцэтгэлээс хасахгүй.

2.8 Үндсэн ажлынхаа зэрэгцээ мэргэжил, ажил, албан тушаал хавсран буюу хослон ажилласан, эзгүй байгаа ажилтны үүргийг орлон гүйцэтгэсэн, ажлын байрны тодорхойлолтод заагаагүй ажил үүргийг гүйцэтгэсэн тохиолдолд тухайн ажилтанд хавсран гүйцэтгэж байгаа албан тушаалын үндсэн цалингийн 40 хүртэл хувиар тооцож нэмэгдэл хөлс олгоно.

2.9 ҮЭ-ийн гишүүн биеийн тамирын багш, ажилтны спортын мастерын нэмэгдлийг тухайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа нөхцөлд зохих журмын дагуу 10 хувиар бодож олгохыг тэдний хөдөлмөрийн гэрээнд тусган шийдвэрлэнэ.

2.10. Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг захиргаа аж ахуйн ажилтан тухайн мэргэжлээрээ ажиллаж байгаа тохиолдолд холбогдох хууль тогтоомж, Засгийн газрын тогтоолын дагуу олгоно.

2.11. ШУТИС-ийн профессор багш, ажилтан өөрийн цалингийн хэмжээ болон бусад нэмэгдлийн талаар мэдээлэл авах эрхтэй. Бүрэлдэхүүн сургуулийн санхүүгийн ажилтан болон хүний нөөцийн ажилтан тухай бүрд нь мэдээлэл өгөх үүргийг хүлээнэ.



Гурав. Ажил амралтын цаг

3.1 Ажлын цагаар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан ҮЭ-ийн гишүүн профессор багш, ажилтны ажлын цагийг суралцаж байх хугацаанд нь ажил олгогч богиносгож, үндсэн цалин, урамшууллыг бүрэн олгоно.

3.2 Хүүхэд хөхүүлэх, асрах завсарлагын цагийг хуульд зааснаар олгох бөгөөд энэхүү цагийг ажлын цагт оруулан тооцно.

3.3 ШУТИС-ийн нийт профессор багш, ажилтан Хөдөлмөрийн тухай хууль, Боловсролын ерөнхий хууль болон ХНХ-ын сайдын 2021 оны 12-р сарын 06-ны өдрийн А/191 тоот тушаалаар баталсан журмын дагуу ээлжийн амралтаа биеэр эдэлж, ээлжийн амралтын олговроо бүрэн авна. Ээлжийн амралтаа бүрэн эдлээгүй профессор багш, ажилтны амралтын үлдсэн хоногийг заавал биеэр эдлүүлнэ.

3.4 Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй профессор багш, ажилтныг тухайн жилд нь багтааж амруулах, нөхөн амруулах боломжгүй бол мөнгөн урамшуулал олгоно. Ажилласан нэг өдрийн мөнгөн урамшууллын хэмжээ нь тухайн албан тушаалтны үндсэн цалингийн нэг өдрийн хөлстэй тэнцүү байна.

3.5 Ажилтны буруу биш шалтгаанаар гарсан сул зогсолтын хугацаанд ажилтныг өөр ажилд шилжүүлэн ажиллуулах, шилжүүлэх боломжгүй бол ажилтанд үндсэн цалингийн 75 хувиар олговор олгоно.

3.6 Шөнийн цагаар болон нийтээр амрах баярын өдөр, долоон хоногийн амралтын өдөр ажилласан ажилтныг нөхөн амруулаагүй бол ХНХ-ын сайдын 2021 оны 12 дугаар сарын 06-ны А/192 тоот тушаалаар баталсан “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”-ын 2.2-т заасны дагуу хөлсийг бодож олгоно.

3.7 Ажил олгогч профессор багш, ажилтанд цалинтай чөлөө олгох асуудлыг Хөдөлмөрийн дотоод журмын дагуу шийдвэрлэнэ.

Дөрөв. Нийгмийн асуудлын талаар

4.1 ШУТИС-ийн багшийг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх үлгэрчилсэн журамд заасны дагуу бүрэлдэхүүн сургууль орлогынхоо 2 хувийг багшийг хөгжүүлэх үйл ажиллагаанд төсөвлөж, зарцуулалтанд талууд хяналт тавина.

4.2 ШУТИС-д тасралтгүй ажилласан профессор, багш, ажилтан 2024 оны 09 дүгээр сараас 2024 оны 12 дугаар сарыг дуустал тэтгэвэрт гарах эрх нь үүссэн бол ҮЭ-ийн гишүүний байдлыг харгалзан үзэхгүйгээр нэг удаагийн тэтгэмж олгоно. 2025 оны 1 дүгээр сарын 02-ны өдрөөс энэхүү заалт нь ШУТИС-ийн ҮЭ-ийн гишүүн профессор, багш, ажилтанд үйлчилнэ.

№	ШУТИС-д ажилласан сарын тоо	Тэтгэмж авах сарын тоо	№	ШУТИС-д ажилласан сарын тоо	Тэтгэмж авах сарын тоо
1	6-24 сар	1 сарын цалин	10	217-228	10 сарын цалин
2	25-60 сар	2 сарын цалин	11	229-240	11 сарын цалин
3	61-120 сар	3 сарын цалин	12	241-252	12 сарын цалин
4	121-156 сар	4 сарын цалин	13	253-264	13 сарын цалин
5	157-168	5 сарын цалин	14	265-276	14 сарын цалин
6	169-180	6 сарын цалин	15	277-288	15 сарын цалин
7	181-192	7 сарын цалин	16	289-300	16 сарын цалин
8	193-204	8 сарын цалин	17	301-312	17 сарын цалин
9	205-216	9 сарын цалин	18	313-325 ба түүнээс дээш	18 сарын цалин

4.3 МУ-ын Засгийн газрын 2010 оны 01-р сарын 20-ны өдрийн 15-р тогтоолоор ШУТИС-д бусад сургуулиас шилжин ирсэн ҮЭ-ийн гишүүн багш нарыг тэтгэвэрт гарахад нь тэтгэмж олгоходоо боловсролын байгууллагад 15-18 жил хүртэл ажилласан профессор багш тэтгэвэрт гарахад 3 сарын; 18-21 жил хүртэл ажилласан багш тэтгэвэрт гарахад 6 сарын; 21-25 жил хүртэл ажилласан багш 9 сарын; 25 ба түүнээс дээш жил ажилласан багш тэтгэвэрт гарахад 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж тус тус олгоно.

4.4 ШУТИС-иас өндөр насны тэтгэвэр авах эрх үүсгэлгүй “Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн болон Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль”-д заасан болзлыг хангаж өндөр насны тэтгэвэр, цэргийн алба хаасны тэтгэвэр өмнө нь тогтоолгосон ШУТИС-ийн профессор багш, ажилтан нарт хамтын гэрээнд заагдсан нэг удаагийн тэтгэмж олгогдохгүй.

4.5 ШУТИС-д ажиллаж байгаа профессор багш, ажилтан нас барвал нэг сарын үндсэн цалинтай тэнцэх, өндөр насны тэтгэвэрт гарсан ахмад настан нас барвал хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй тэнцэх буцалтгүй тусламжийг гэрт нь олгоно.

4.6 Профессор багш, ажилтны төрсөн эцэг эх, ах эгч дүү, нөхөр эхнэр, хүүхэд нь нас барвал 500 000 төгрөгийн тусламж үзүүлнэ.

4.7 Өөрийн оршин суудаг гэр орон нь гал түймэр, үер усны гэх мэт давагдашгүй хүчин зүйлд өртсөн тохиолдолд ҮЭ-ийн гишүүн профессор багш, ажилтанд 1 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тусламж олгоно.

4.8 Төрийн байгууллагад 20-иос доошгүй жил, үүнээс ШУТИС-д 10-аас доошгүй жил ажилласан ҮЭ-ийн гишүүн профессор багш, ажилтанд ээлжийн амралтаараа магадлан итгэмжлэл бүхий эмнэлгийн байгууллагын шийдвэрээр дотоодын сувилал, эмчилгээнд явах тохиолдолд 300000 хүртэл төгрөгийн буцалтгүй тэтгэмжийг холбогдох баримт үндэслэн 3 жилд нэг удаа олгох асуудлыг ШУТИС-ийн захиргааны ажилтанд захиргааны зөвлөлийн, бүрэлдэхүүн сургууль захирлын зөвлөлийн хурлаар тус тус шийдвэрлэнэ.

4.9 Сургууль, салбар нэгжийн хамт олны өдөрлөг, арга хэмжээг зохион байгуулахад зориулан Горхи дахь полигонд очих, ирэх унааны зардал болон холбогдох бусад зардлыг жилд 1 удаа тухайн сургууль, нэгж хариуцан гаргана.

4.10. Ахмад настныг цагаан сар, ахмадын баярын өдрийг тохиолдуулан жилд 2-оош доошгүй удаа хүлээн авч, хүндэтгэл үзүүлнэ.

4.11. ШУТИС-д ажиллаж байгаа профессор багш, ажилтан эрэгтэй 60, эмэгтэй 55 нас хүрэхэд нэг удаа 300000 төгрөгийн зардал гаргаж, хүндэтгэл үзүүлнэ.

4.12. Тус сургуульд 5-аас дээш жил хариуцсан ажилдаа идэвх зүтгэлтэй ажилласан ҮЭ-ийн гишүүн ажилтан бакалавр, магистрын түвшинд суралцах эрхийн шаардлага хангасан хүний ШУТИС-д суралцахаар сонгосон мэргэжлээр нь суралцах хугацаанд нь нэг хичээлийн жилийн сургалтын төлбөрийг 50%-иар нэг удаа хөнгөлж суралцуулна.

4.13. ШУТИС-ийн профессор багш, ажилтан докторын зэргийн урьдчилсан хамгаалалтаа амжилттай хийсэн бол 1 500 000 төгрөгийн тэтгэмжийг нэг удаа олгоно.

4.14. Багш нарын баярын өдрийг тохиолдуулан холбогдох журамд заасны дагуу шилдэг профессор багшийг шалгаруулан шагнаж урамшуулна. Урамшууллыг ШУТИС-ийн төсөвт тусгасан зардлаас гаргана.

4.15. Профессор багш, ажилтныг орон сууцаар хангах зорилгоор арилжааны банкууд, орон сууцны корпорац, аж ахуйн нэгж, хувь хүнтэй гэрээ байгуулж, орон сууц авах багш, ажилтныг хөнгөлөлттэй урт хугацааны зээлд хамруулах ажлыг үргэлжлүүлэн зохион байгуулах үүргийг санхүү, хөрөнгө оруулалтын алба хүлээнэ.

4.16. ШУТИС-ийн Эрдмийн зөвлөлийн дэргэдэх Ном сурах бичгийн зөвлөл, бүрэлдэхүүн болон салбар сургуулийн Эрдмийн зөвлөлийн хурлын шийдвэрээр зөвшөөрөгдсөн сурах бичиг, сургалтын гарын авлагыг хэвлүүлэх, олон улсын мэргэжлийн түвшинд хянагддаг сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх эрх авсан профессор багш, ажилтанд хэвлэлтэй холбоотой зардлыг бүрэлдэхүүн сургуулийн Захирлын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ.

4.17. ШУТИС-д 15-аас доошгүй жил үр бүтээлтэй ажиллаж байгаа профессор багш, ажилтан хүнд өвчин (эмнэл зүйн, лабораторийн аргаар мэргэжлийн байгууллагаар тодорхойлсон дүгнэлт)-ийн улмаас эх орондоо болон гадаад улсад 10 сая төгрөгөөс дээш төлбөртэй эмчилгээ хийлгэх тохиолдолд ШУТИС-ийн Ректорын зөвлөлийн шийдвэрээр харьяалах нэгж нь 2 сая төгрөг, бүрэлдэхүүн сургууль, захиргаа тус бүр 200000 төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлнэ.

Тав. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл

5.1 Монгол Улсын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 26.2-т заасны дагуу сургууль бүр төсвийн хөрөнгөөр нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний зардлын 0.5%-иас доошгүй хэмжээний хөрөнгийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн болон үйлдвэрийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулна. ШУТИС-ийн Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл төлөвлөгөө гаргаж хариуцан ажиллана. Зарцуулалтыг жилд 2 удаа тайлагнана.

5.2 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөлд талууд ижил тэгш эрхтэй оролцоно. Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орон тооны бус зөвлөл нь хөдөлмөр зохион байгуулалтыг сайжруулах, ажлын байр, хөдөлмөрийн нөхцөлд үзлэг шалгалт хийх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомжийг сурталчлах ажлыг төлөвлөгөө гаргаж, зохион байгуулна.

5.3 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангах, хөдөлмөр хамгааллыг сайжруулах арга хэмжээний хөтөлбөрийг ҮЭХ-той зөвшилцөн баталж мөрдүүлнэ.

5.4 Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хуулийн 65.4.2, 80.1.1, 80.1.2-т заасан үндэслэлээр ажлаас халагдсан профессор багш, ажилтанд тус хуулийн 82-р зүйлийн 82.1-д заасан хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.

5.5 ШУТИС-ийн Захиргаа нь ҮЭНХ-той зөвшилцөн, Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссыг эрчимжүүлж ажиллуулна.

5.6 Мэргэжлийн онцлогоос хамааруулан, ажлын байрны нөхцөлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, шаардлагатай хөрөнгийг 5.1-т заасан сангаас гаргана. Зохих арга хэмжээг сургуулийн захиргаа, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хариуцсан орон тооны бус зөвлөл авна.

5.7 Хөдөлмөр хамгаалах хэрэгслийн жагсаалтыг шинэчлэн, Стандарт, хэмжил зүйн газраас тогтоосон норм, журмын дагуу хүрэлцэхүйц хэмжээгээр захиалж, хугацаанд нь олгоно.

5.8 Хүнд, хортой нөхцөлд ажилладаг ҮЭ-ийн гишүүн профессор багш, ажилтан, сургалтын мастер, архивын ажилтан /үүнд архив хариуцан ажиллаж буй албан тушаалтан хамаарна/, хортой нөхцөлд УВЧ аппарат, парафин лаа эмчилгээ хийдэг физик эмчилгээний эмч, номын санч, бохирын слесарь, ариун цэврийн өрөөний үйлчлэгч нарт ажлын өдөр бүр хор саармагжуулах хүнсний бүтээгдэхүүн болох 0.5 литр сүүг олгоно. Эдгээр албан тушаал дээр ажиллаж буй хүн болон бүх үйлчилгээний ажилтанд харшлын сорил тавиулах ажлыг сургуулийн захиргаанаас жилд нэг удаа зохион байгуулж, гарах зардлыг 5.1-д заасан сангаас гаргана.

5.9 Үйлчилгээний ажилтанд олгох ажлын хувцас, багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материалын чанарыг сайжруулж, хүний биед хоргүй угаалгын бодисыг зохих нормын дагуу сургуулиуд нь хариуцан олгоно. Эдгээр зүйл чанарын шаардлага хангаж буй эсэхийг ХАБЭА хариуцсан орон тооны бус зөвлөлөөс улиралд нэг удаа шалган дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчил дутагдлыг засах арга хэмжээ авна.

5.10. Тоостой /тоосонцортой/ нөхцөлд ажилладаг номын сан, архивын болон сургалтын албаны ажилтны ажлын байрны нөхцөлийг сайжруулж, агаар чийгшүүлэгч суурилуулж, арчих, цэвэрлэгээний материал олгоно.

5.11. ШУТИС-ийн хичээлийн байруудыг жилд 2 удаа ариутгаж, халдваргүйжүүлэлт, мэрэгчийн устгалыг мэргэжлийн байгууллагаар хийлгэнэ. Үүнтэй холбогдох зардлыг гэрээний 5.1 дэх заалтын дагуу бүрдүүлэх хөрөнгөөс гаргана.

5.12. Профессор багш, ажилтны ажлын байрны эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулж, хичээл зааж буй анги танхмийн агааржуулалт, эрүүл ахуй, галын аюулгүй байдлыг хангана. Подвалд байрлаж байгаа профессор багш, ажилтны өрөөний гэрэлтүүлэг, агааржуулалт зэргийг эрс сайжруулж, стандарт хэмжээнд хүргэх арга хэмжээ авна.

5.13. ШУТИС-ийн хичээлийн байрны ариун цэврийн өрөөний тохижилтыг сайжруулж, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гар угаах шингэн саван, ариутгагч уусмал, гар хатаагч, багш нарын өрөө болон коридорт ус цэвэршүүлэгч зэргийг байршуулна.

5.14. ШУТИС-ийн цайны газрын тохижилт, хоолны чанар, ариун цэврийг дээшлүүлж, тогтмол ажиллагаатай болгох үүргийг ажил олгогч хүлээнэ.

5.15. МУ-ын Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14-р зүйлийг үндэслэн, ШУТИС-ийн профессор багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулна. Эрүүл мэндийн үзлэг хийлгэхэд шаардагдах зардлыг ажил олгогч хариуцах бөгөөд 1 хүнд 40000 төгрөгөөр бодож, сургуулийн зүгээс санхүүжүүлнэ. Хэрэв ажил олгогч эрүүл мэндийн үзлэгт тухайн жилд хамруулж чадаагүй бол дараа жилийн 1-р улиралд багтаан хамруулах бөгөөд санхүүжилтийг шилжих үлдэгдлээс шийдвэрлүүлнэ.

Зургаа. Талуудын хамтын ажиллагаа

6.1 Мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор ажил олгогч ҮЭ-тэй хамтран, бүрэлдэхүүн сургуулийн удирдах албан тушаалтан, профессор багш, ажилтанд зориулан, жилд 1-ээс доошгүй удаа төрөл бүрийн сургалт зохион байгуулна.

6.2 Үйлдвэрчний эвлэлийн ажилтан, сонгуультанд тухайн сонгуульт ажилтай нь холбогдуулан, сахилгын шийтгэл ногдуулах, хэлэлцээрт оролцсоных нь төлөө өөр ажилд шилжүүлэх, ажил олгогчийн санаачилгаар хэлэлцээний туршид болон хэлэлцээ дууссанаас хойш нэг жилийн дотор ажлаас халахыг хориглоно.

6.3 ШУТИС-ийн хамтын удирдлагын байгууллагад Үйлдвэрчний эвлэлийн төлөөллийг оруулна.

6.4 ҮЭ-ийн гишүүдийн татварыг цаг тухайд нь салбар хороодын данс руу бэлэн бусаар хурааж шилжүүлэх үүргийг бүрэлдэхүүн сургууль, бусад нэгж хүлээнэ.

6.5 ҮЭ-ийн төлөөлөгчид дараах комисс, зөвлөлийн үйл ажиллагаанд заавал оролцоно. Үүнд:

- Хамтын гэрээний хэрэгжилтийг хянах комисс,
- Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс,
- Үйлдвэрийн ослын шалтгаан тогтоох комисс,
- Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл.

6.6. Хөдөлмөрийн харилцаа, Боловсролын салбарын хууль тогтоомжийн төсөлд санал өгөх, танин мэдүүлэх тал дээр гэрээнд оролцогч талууд хамтран ажиллана.

Долоо. Гэрээний биелэлтийг хянах, мэдээлэх

7.1 Захиргааны зүгээс профессор багш, ажилтны санал хүсэлтийг жилд нэг удаа нэгдсэн журмаар сонсож Хамтын гэрээний биелэлт, хэрэгжилтийн талаар мэдээлнэ.

7.2 Хоёр тал гэрээний хэрэгжилттэй холбоотой өөрт байгаа бүх мэдээллийг нээлттэй солилцоно.

7.3 Хамтын гэрээний хэрэгжилтэд талууд хяналт тавина.

7.4 Хамтын гэрээг биелүүлэх явцад үүссэн саналын зөрүүтэй асуудлыг “Хөдөлмөрийн тухай” хуулийн 11 дүгээр бүлэгт заасны дагуу шийдвэрлэнэ.



ХАМТЫН ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Ажил олгогчийг төлөөлж:

ШУТИС-ийн Сургагч, цахим шилжилт эрхэлсэн
проректор Н.Эрдэнэхүү

ШУТИС-ийн Санхүү хөрөнгө оруулалтын албаны
дарга Г.Жавхлан

БАС-ийн захирал Б.Нарантуяа

МеТС-ийн захирал Н.Пүрэвдорж

ХШУС-ийн захирал В.Өлзийбаяр

Ажилтныг төлөөлж:

ШУТИС-ийн дэргэдэх ҮЭХ-ны дарга
..... С.Дэлгэрмаа

БуХС-ийн ҮЭ-ийн салбар хорооны дарга
..... С.Болормаа

МХТС-ийн ҮЭ-ийн салбар хорооны дарга
..... Ц.Балжинням

МеТС-ийн ҮЭ-ийн салбар хорооны дарга
..... З.Баатар

БАС-ийн ҮЭ-ийн салбар хорооны дарга
..... Б.Бизъяасүрэн



2024-2025 оны хичээлийн жилийн хамтын гэрээний ажлын төлөвлөгөө

No	Гүйцэтгэх ажил	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах эзэн
1.	ШУТИС-ийн дотоод үйл ажиллагааны болон санхүүгийн төлөвлөгөөг санхүүгийн жилээр төлөвлөх	2025.01 сар	Санхүү, хөрөнгө оруулалтын газар
2	ШУТИС-ийн Хүний нөөцийн бодлогын баримт бичгийг үндэслэн ажлын байрны тодорхойлолт шинэчлэн боловсруулж, баталж мөрдөх	2024.09-12 сар	Ректорын ажлын алба, Хүний нөөцийн алба, ҮЭХ
3	Хөдөлмөрийн маргаан таслах комиссыг ажиллуулах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа, ҮЭХ
4	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн байдал, осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулсан сан байгуулж, зарцуулалтын төлөвлөгөө гаргаж, баталж, мөрдүүлэх	Жилийн турш	Санхүү, хөрөнгө оруулалтын газар, бүрэлдэхүүн сургуулиудын захирлууд, ҮЭСХороод
5	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөлийн үйл ажиллагааг жигдрүүлэн ажиллуулах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа
6	Ажилчдад олгох ажлын хувцас, багаж хэрэгсэл, үйлчилгээний ажилчдад олгох цэвэрлэгээний материал чанарын шаардлага хангаж буй эсэхийг шалган дүгнэлт гаргаж, илэрсэн зөрчил дутагдлыг засах арга хэмжээ авч ажиллах	Улиралд нэг удаа	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан орон тооны бус зөвлөл
7	“ШУТИС-ийн багшийг хөгжүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх үлгэрчилсэн журам”-ын дагуу бүрэлдэхүүн сургууль бүр хөрөнгө төвлөрүүлж, зарцуулах ажлын төлөвлөгөө гаргах	2025.01 сар	Бүрэлдэхүүн сургуулиудын захиргаа, ҮЭСХороод
8	Багш, ажиллагсдад орон сууц авахад нь дэмжлэг үзүүлэх, арилжааны банк, орон сууцны корпорац, аж ахуйн нэгж, хувь хүнтэй гэрээ байгуулах, зээлд хамруулах ажлыг эрчимжүүлж ажиллах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа
9	Хичээлийн байруудын ариутгал, халдваргүйжүүлэлт, мэрэгч, амьтан устгах ажлыг зохион байгуулах	Жилд 2 удаа	Хангамж үйлчилгээний алба, байр хариуцсан менежер
10	Цайны газруудын ариун цэвэр, хоолны чанарт хяналт тавих	Жилийн турш	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, хангамж үйлчилгээний алба
11	Хичээлийн байрнуудын ариун цэврийн өрөөний тохижилтыг хариуцаж хийлгэх. Багш нарын өрөө, коридорт ус цэвэршүүлэгч байршуулах ажлыг хийлгэх.	Жилийн турш	Хангамж үйлчилгээний алба, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл, байр хариуцсан менежер
12	Багш нарын өрөөний галын аюулгүй байдлыг хангах, агааржуулалт, гэрэлтүүлэг зэргийг стандартын шаардлагын дагуу суурилуулж, ажиллуулах	Жилийн турш	СХО алба, бүрэлдэхүүн сургуулиудын захиргаа, Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн асуудал хариуцсан зөвлөл
13	ШУТИС-ийн нийт профессор багш, ажилтныг эрүүл мэндийн үзлэгт хамруулах	Жилийн турш	ШУТИС-ийн Захиргаа, Хүний нөөцийн газар